



ЭМ ХАНГАМЖИЙН  
БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН  
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Энхтайван найрамдлын ордон, Энхтайваны өргөн чөлөө,  
3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: 26 01 82, Цахим шуудан: info@mmra.gov.mn,

Цахим хуудас: www.mmra.gov.mn

2026.09.18

№

01/1464

танай

-ны №

-т

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 38, 30 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулан тусгай зөвшөөрөл бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан зэрэг хангамжийн байгууллагын шатлал бүрд эмийн нэр төрөл, үнэ, цувралын мэдээлэл солилцох байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг үе шаттай хийж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.7 -д эм хангамжийн байгууллага эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн ил тод байдлыг хангах, цувралын дугаар, стандарт код, тоо хэмжээг тухай бүр цахим санд оруулах үүргийг тус тус заасан.


"Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн эм холбоо" ТББ, "Монголын эм хангамжийн шинэчлэл холбоо" ТББ болон ханган нийлүүлэх байгууллагуудтай 2026 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр уулзалт хийж "Цахим мэдээллийн нэгдсэн сан"-д и-баримт системтэй мэдээлэл солилцож, цувралаар мөшгих тогтолцоог бүрдүүлэхээр болсон.

Дээрх холболт хийгдэж, бодит цагийн горимоор Эм, эмнэлгийн хэрэгслийн улсын нөөцийн мэдээллийг бүрэн хянадаг болтол эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээллийг цуврал тус бүрээр 7 хоногт 1 удаа <https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock>, сервисээр систем хооронд мэдээлэл солилцож бүрдүүлэхээр болсон. Иймд 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн дотор өөрсдийн программ нийлүүлэгч байгууллагатай хамтран дээрх сервисийн хөгжүүлэлтийг хийж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хувийг: "Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн эм холбоо" ТББ, "Монголын эм хангамжийн шинэчлэл холбоо" ТББ-д

Хавсралт 9. хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.АЛТАНЦЭЦЭГ

1526

151438

# Цувралын үлдэгдлийн API – Интеграцийн заавар

Энэ баримт бичгийг **программ хангамжийн байгууллага (вендор)**-т өгнө.

Эм ханган нийлүүлэгч, эмийн сан, дотоодын үйлдвэрүүд өөрсдийн системээс **цуврал тус бүрийн үлдэгдлийг 7** хоног тутам илгээнэ.

Зөвхөн эмд зориулаагүй — эмнэлгийн хэрэгсэл (оношлуур, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж), эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг мөн энэ эндпойнтоор илгээнэ.

## 1. Үндсэн мэдээлэл

|          |                                                                                                                    |
|----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Endpoint | POST <a href="https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock">https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock</a> |
| Аргачлал | HTTP POST, JSON body, <code>Content-Type: application/json</code>                                                  |
| Нэвтрэлт | <code>x-api-key: &lt;таны нууц түлхүүр&gt;</code> (header)                                                         |
| Давтамж  | 7 хоног тутам нэг удаа                                                                                             |
| Шифрлэлт | HTTPS заавал                                                                                                       |

## 2. Хүсэлтийн формат (request body)

```
{
  "balance_date": "2026-09-10",
  "idempotency_key": "org9087443-stock-2026-09-10-1",
  "rows": [
    {
      "org_reg_no": "9087443",
      "org_type": "SUPPLIER",
      "origin": "IMPORTED",
      "special_type": "REGULAR",
      "registration_no": "F20090529AP02140",
      "barcode": "6900000000001",
      "batch_no": "B-2026-001",
      "quantity": 1250.5
    },
    {
      "org_reg_no": "9087443",
      "org_type": "FACTORY",
      "origin": "DOMESTIC",
      "special_type": "REGULAR",
      "registration_no": "L20150520T004742",

```

```

    "barcode": "6900000000002",
    "batch_no": "DOM-2026-014",
    "quantity": 500,
    "expiry_date": "2028-01-31",
    "manufacture_date": "2026-01-31"
  },
  {
    "org_reg_no": "9087443",
    "org_type": "SUPPLIER",
    "origin": "IMPORTED",
    "item_type": "DEVICE",
    "registration_no": "F130618ImE00003",
    "barcode": "8000000000003",
    "batch_no": "DV-2026-007",
    "quantity": 20
  }
]
}

```

- `balance_date` — **ЗААВАЛ**, `YYYY-MM-DD`. Үлдэгдэл нь **ямар өдрийн байдлаарх** болохыг заана. Энэ нь давхардлын түлхүүрийн нэг хэсэг тул **долоо хоног бүрийн үлдэгдэл тусдаа мөр болж түүх хуримтлагдана**.
- `rows` — нэг хүсэлтэд **хамгийн ихдээ 50,000 мөр**. Их бол хэд хэдэн хүсэлтэд хувааж (chunk) илгээнэ.
- `idempotency_key` — **ЗААВАЛ**, илгээлт бүрд **давтагдашгүй** байна. Сүлжээ тасарч дахин илгээхэд хоёр багц үүсэхээс сэргийлнэ.
  - Ижил key-тэй хоёр дахь илгээлт **боловсруулагдахгүй**, өмнөх багцын хариу буцна. Ижил key-ийг зөвхөн **яг ижил датаг дахин илгээхэд** ашиглана.
  - Санал болгох хэлбэр: `org<reg>-stock-<орноо>-<дараалал>`.
  - **Илгээсэн үлдэгдлээ ЗАСАХ бол** — шинэ key-ээр дахин илгээнэ. Ижил `balance_date` -тэй мөр дарж бичигдэнэ.

### 3. Мөр (row) бүрийн талбарууд

| # | JSON түлхүүр            | Монгол нэр         | Төрөл | Заавал | Тайлбар                                                                                                         |
|---|-------------------------|--------------------|-------|--------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | <code>org_reg_no</code> | Регистрийн дугаар  | text  | ✓      | Илгээгч байгууллагын улсын бүртгэлийн дугаар — <b>ЯГ 7 оронтой тоо</b> (нэр биш). Жишээ: <code>"9087443"</code> |
| 2 | <code>org_type</code>   | Байгууллагын төрөл | enum  | ✓      | <code>PHARMACY</code> / <code>SUPPLIER</code> / <code>FACTORY</code>                                            |
| 3 | <code>origin</code>     | Гарал үүсэл        | enum  | ✓      | <code>DOMESTIC</code> (дотоодын) / <code>IMPORTED</code> (импортын)                                             |

| #  | JSON түлхүүр     | Монгол нэр           | Төрөл  | Заавал                                                                            | Тайлбар                                                                                 |
|----|------------------|----------------------|--------|-----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------|
| 4  | registration_no  | Бүртгэлийн дугаар    | text   |  | Өнчин эм / даргын тушаалын эмээс бусад бүх тохиолдолд заавал. Жишээ: "F20090529AP02140" |
| 5  | barcode          | Савлалтын баркод     | text   |  | Тухайн савлалтыг заана. Жишээ: "6900000000001"                                          |
| 6  | batch_no         | Цувралын дугаар      | text   |  | Жишээ: "B-2026-001"                                                                     |
| 7  | quantity         | Үлдэгдэл             | number |  | Бутархай зөвшөөрнө. 0 байж БОЛНО (дууссан). Сөрөг байж болохгүй                         |
| 8  | item_type        | Бүтээгдэхүүний төрөл | enum   | —                                                                                 | MEDICINE (анхдагч) / DEVICE / SUPPLEMENT . Заагаагүй бол эм гэж үзнэ                    |
| 9  | special_type     | Эмийн ангилал        | enum   |  | item_type=MEDICINE үед заавал. Энгийн эмд REGULAR . Бүх утгыг доор үз                   |
| 10 | branch_no        | Салбарын дугаар      | text   |  | org_type=PHARMACY үед заавал. Бөөнд шаардлагагүй. Жишээ: "BR-01"                        |
| 11 | expiry_date      | Дуусах хугацаа       | date   |  | origin=DOMESTIC ба org_type=FACTORY үед заавал. YYYY-MM-DD                              |
| 12 | manufacture_date | Үйлдвэрлэсэн огноо   | date   |  | origin=DOMESTIC ба org_type=FACTORY үед заавал. YYYY-MM-DD                              |

**item\_type — ямар бүтээгдэхүүн вэ**

| Утга       | Хамрах хүрээ                                                                    |
|------------|---------------------------------------------------------------------------------|
| MEDICINE   | Эм. Анхдагч утга — заагаагүй бол энэ гэж үзнэ                                   |
| DEVICE     | Эмнэлгийн хэрэгсэл — оношлуур, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүгд энд багтана |
| SUPPLEMENT | Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн                                               |

**Яагаад бүртгэлийн дугаар, баркод хоёулаа хэрэгтэй вэ**

Хоёр өөр зүйлийг заадаг:

- registration\_no → БҮТЭЭГДЭХҮҮН. Аль бүтээгдэхүүний тухай яриа өрнөж байгаа.
- barcode → САВЛАЛТ. Нэг бүртгэлтэй бүтээгдэхүүн олон савлалттай байдаг (10 ширхэгтэй, 30 ширхэгтэй г.м.), савлалт бүр өөр баркодтой.

Зөвхөн бүртгэлийн дугаар авбал өөр савлалтуудын үлдэгдэл нийлж алдагдана.

**special\_type — ЭМИЙН АНГИЛАЛ**

item\_type = MEDICINE үед заавал. Эмнэлгийн хэрэгсэл, нэмэлт бүтээгдэхүүнд энэ талбар хамаарахгүй.

| Утга           | Утга учир                      | Бүртгэлийн дугаар |
|----------------|--------------------------------|-------------------|
| REGULAR        | Энгийн эм                      | ✅ байна           |
| EXPEDITED      | Түргэвчилсэн журмаар бүртгэсэн | ✅ байна           |
| CONDITIONAL    | Нөхцөлт бүртгэл                | ✅ байна           |
| HERBAL         | Уламжлалт (ургамлын гаралтай)  | ✅ байна           |
| ORPHAN         | Өнчин эм                       | ❌ байхгүй         |
| DIRECTOR_ORDER | Даргын тушаалын эм             | ❌ байхгүй         |

Эхний дөрөвт нь `registration_no` **заавал** — өөр нэмэлт талбар шаардахгүй. Энгийн эмд `"special_type": "REGULAR"` гэж бичихэд л хангалттай.

`special_type` -ыг **заавал** болгосон шалтгаан: үүнгүйгээр «бүртгэлийн дугаараа бичихээ мартсан» мөр болон «жинхэнэ өнчин эм» хоёрыг ялгах арга байхгүй. Эхнийх нь алдаа хэвээр байх ёстой.

### Өнчин эм ба даргын тушаалын эм — бүртгэлийн дугааргүй

Зөвхөн энэ хоёр ангилалд **бүртгэлийн дугаар огт олгогддоггүй** — зөвлөлөөр батлагдсаны дараа ч дугааргүй хэвээр үлддэг.

Тэдгээрийг **олон улсын нэршил, хэлбэр, тун** гурвалаар тодорхойлдог бөгөөд хангамжийн байгууллага өөрийн мэдүүлэг дээрээ **худалдааны нэрээ** үүсгэдэг. Тиймээс таних утга нь **таны мэдүүлэг дээр байгаа шинжүүд** байна.

Ийм мөрд `registration_no` -г **орхиод** дараах таван талбарыг илгээнэ:

| Талбар                    | Монгол нэр                                   | Жишээ                   |
|---------------------------|----------------------------------------------|-------------------------|
| <code>inn</code>          | Олон улсын нэршил (үйлчлэгч бодисын нийлбэр) | <code>"Imatinib"</code> |
| <code>dosage_form</code>  | Эмийн хэлбэр                                 | <code>"Шахмал"</code>   |
| <code>strength</code>     | Тун хэмжээ                                   | <code>"400 мг"</code>   |
| <code>trade_name</code>   | Худалдааны нэр (мэдүүлэг дээрх)              | <code>"Гливек"</code>   |
| <code>manufacturer</code> | Үйлдвэрлэгч                                  | <code>"Novartis"</code> |

```
{
  "org_reg_no": "9087443",
  "org_type": "SUPPLIER",
  "origin": "IMPORTED",
  "special_type": "ORPHAN",
  "inn": "Imatinib",
  "dosage_form": "Шахмал",
  "strength": "400 мг",
```

```
{
  "trade_name": "Гливек",
  "manufacturer": "Novartis",
  "barcode": "9500000000003",
  "batch_no": "ORP-2026-001",
  "quantity": 30
}
```

**Том/жигжиг үсэг, илүү зай хамаагүй.** Систем эдгээр шинжийг нормчилж харьцуулна — "IMATINIB", " Imatinib ", "imatinib" гурав нэг мөр болно.

## Дүрмүүд

- **org\_reg\_no** формат — ЯГ 7 оронтой тоо ( `^\d{7}$` ). Байгууллагын нэр эсвэл өөр урттай утга илгээвэл тэр мөр **татгалзана**.
- **Огноо** — ISO 8601 ( `YYYY-MM-DD` ).
- **Тоо** — тоон утга ( `"100"` эсвэл `100` хоёулаа болно).

## 4. Давхардлын дүрэм (upsert)

Дараах **долоо** нь адил бол нэг мөр гэж үзэж **дарж бичнэ**:

```
org_reg_no + branch_no + item_type + бүтээгдэхүүн + barcode + batch_no + balance_date
```

Дээрх **бүтээгдэхүүн** нь:

- энгийн үед → `registration_no`
- бүртгэлийн дугааргүй үед → `special_type` + `inn` + `dosage_form` + `strength` + `manufacturer`

Эдгээрийг систем **нормчилж** харьцуулна (том/жигжиг үсэг, илүү зай хамаагүй).

| Нөхцөл                                                      | Үр дүн                                                  |
|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------|
| Ижил өдрийг дахин илгээв                                    | Тэр өдрийн тоо <b>засагдана</b> (мөр олшрохгүй)         |
| Өөр өдөр илгээв                                             | <b>Шинэ мөр</b> — долоо хоног бүрийн түүх хуримтлагдана |
| Ижил бүтээгдэхүүний өөр савлалт (баркод)                    | <b>Тусдаа мөр</b>                                       |
| Өнчин эмийг шинжээ өөр үсгээр бичиж илгээв                  | <b>Нэг мөр</b> — нормчилж харьцуулна                    |
| Бөөний ( <code>SUPPLIER</code> / <code>FACTORY</code> ) мөр | <code>branch_no</code> хоосон гэж тооцогдоно            |

Тиймээс **долоо хоног бүр бүтэн жагсаалтаа илгээхэд** аюулгүй — давхардал үүсэхгүй, харин үлдэгдлийн өөрчлөлтийн түүх бүрдэнэ.

## 5. Дотоодын цувралыг бид бүртгэж авна

Дотоодын үйлдвэрлэлд улсын хэмжээнд цуврал мөшгих тогтолцоо байгаагүй — өнөөдөр бүртгэлтэй цуврал бүгд гаалийн мэдүүлгээр орж ирсэн импортынх.

Тиймээс **дотоодын эмийн цувралыг та ирүүлэхэд бид түүнийг автоматаар бүртгэж авна** — цувралын бүртгэлд шинэ мөр үүсч, тухайн үлдэгдэл түүн дээр холбогдоно. Дараагийн удаа ижил цувралыг илгээхэд **давхар үүсэхгүй**.

|                  |                                                                                                                        |
|------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хэзээ бүртгэгдэх | Эм нь дотоодынх, цуврал өмнө бүртгэгдээгүй, бөгөөд <code>expiry_date</code> ирсэн үед                                  |
| Юу хадгалагдах   | Цувралын дугаар, дуусах хугацаа, үйлдвэрлэсэн огноо                                                                    |
| Төлөв            | <code>REPORTED</code> — үйлдвэрээс <b>мэдүүлсэн</b> . Зохицуулагч байгууллага хараахан баталгаажуулаагүй гэсэн утгатай |

**Яг иймд `expiry_date`, `manufacture_date` хоёр нь дотоодын үйлдвэрийн мөрд заавал.**

Хугацаагүй цуврал бүртгэвэл хугацаа дуусах хяналт, тайлан ажиллахгүй хагас дутуу бичлэг үлдэнэ.

Дотоодын эмийг **нийлүүлэгч** мэдээлж болох ба тэр үед хугацаа шаардагддаггүй. Хугацаагүй ирвэл **цуврал үүсэхгүй** — үлдэгдэл нь хэвээр хадгалагдаад, цувралыг нь үйлдвэр өөрөө мэдүүлэхэд бүртгэгдэнэ.

**Импортын цуврал бүртгэгдэхгүй.** Тэдгээр нь гаалийн мэдүүлгээр илүү бүрэн мэдээлэлтэй орж ирдэг. Давхардуулж үүсгэвэл нэг цуврал хоёр эх сурвалжтай болж зөрчилдөнө. Импортын мөрийн үлдэгдэл хэвийн хадгалагдана.

**Эмнэлгийн хэрэгсэл, нэмэлт бүтээгдэхүүнд** цувралын бүртгэлийн хүснэгт байхгүй тул зөвхөн үлдэгдэл нь хадгалагдана.

## 6. Жишээ хүсэлт (curl)

```
curl -X POST https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock \
-H "x-api-key: isk_TAHY_TYLXYYP" \
-H "Content-Type: application/json" \
-d '{
  "balance_date": "2026-09-10",
  "idempotency_key": "org9087443-stock-2026-09-10-1",
  "rows": [
    {
      "org_reg_no": "9087443",
      "org_type": "FACTORY",
```

```
"origin": "DOMESTIC",
"special_type": "REGULAR",
"registration_no": "L20150520T004742",
"barcode": "6900000000002",
"batch_no": "DOM-2026-014",
"quantity": 500,
"expiry_date": "2028-01-31",
"manufacture_date": "2026-01-31"
}
]
}'
```

## 7. Хариу (response)

### Амжилттай хүлээн авсан ( 200 )

```
{
  "success": true,
  "data": { "batch_id": 12, "status": "RECEIVED", "row_total": 1 }
}
```

**RECEIVED** нь **хүлээн авсан** гэсэн үг — боловсруулалт цаана үргэлжилнэ. Үр дүнг 8-р хэсгийн эндпойнтоор шалгана.

### Давтан илгээсэн (ижил **idempotency\_key** )

```
{
  "success": true,
  "data": { "id": 12, "status": "PROCESSED", "row_total": 1, "batch_id": 12, "reused": true }
}
```

**reused: true** — шинэ мөр боловсруулагдаагүй, өмнөх багц буцсан.

### Алдаа ( 400 / 401 )

```
{ "success": false, "message": "balance_date заавал (YYYY-MM-DD) – үлдэгдэл ямар өдрийн байдлаарх
```

| Код | Утга                                                                                                                      |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 400 | Хүсэлтийн формат буруу ( <b>rows</b> хоосон, <b>balance_date</b> эсвэл <b>idempotency_key</b> дутуу, 50,000-аас олон мөр) |
| 401 | <b>x-api-key</b> буруу эсвэл идэвхгүй                                                                                     |

| Код | Утга                             |
|-----|----------------------------------|
| 403 | Тухайн багц таны түлхүүрийнх биш |

## 8. Боловсруулалтын төлөв шалгах

```
curl https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock/batches/12 \
-H "x-api-key: isk_ТАНЫ_ТҮЛХҮҮР"
```

```
{
  "success": true,
  "data": {
    "id": 12,
    "status": "PARTIAL",
    "row_total": 7,
    "row_accepted": 5,
    "row_rejected": 2,
    "batches_created": 1,
    "error_summary": {
      "errors": [
        { "row_index": 5, "errors": ["origin заавал (DOMESTIC|IMPORTED)"] },
        { "row_index": 6, "errors": ["item_type буруу (MEDICINE|DEVICE|SUPPLEMENT)"] }
      ]
    }
  }
}
```

| status     | Утга                                                   |
|------------|--------------------------------------------------------|
| RECEIVED   | Хүлээн авсан, боловсруулаагүй                          |
| PROCESSING | Боловсруулж байна                                      |
| PROCESSED  | Бүх мөр амжилттай                                      |
| PARTIAL    | Зарим мөр алдаатай ( <code>error_summary</code> -г үз) |
| FAILED     | Бүх мөр татгалзсан                                     |

- `row_index` нь таны илгээсэн `rows` массив дахь **0-ээс эхэлсэн** дугаар.
- `batches_created` — тухайн илгээлтээр **шинээр бүртгэгдсэн дотоодын цувралын тоо**.
- Алдаатай мөр **бусад мөрийг зогсоохгүй** — зөвхөн өөрөө татгалзана.
- Алдаагаа зассаны дараа **шинэ `idempotency_key` -ээр** зөвхөн тэр мөрүүдийг дахин илгээнэ.

## 9. Талбарын жагсаалтыг API-аас авах

```
curl https://pmd.hdc.gov.mn/api/v1/integration/stock/schema \
-H "x-api-key: isk_ТАНЬ_ТҮЛХҮҮР"
```

Шаардлагатай/сонголтот талбарууд, дүрмийг **хамгийн шинэ** байдлаар буцаана. Энэ баримт бичгээс зөрвөл **API-гийн хариу зөв**.

## 10. Дүрэм ба зөвлөмж

1. **7 хоног тутам бүтэн жагсаалтаа илгээ**. Үлдэгдэл нь төлөв тул давхардахгүй.
2. **idempotency\_key** -г илгээлт бүрд шинээр үүсгэ. Ижил key = «яг ижил дата дахин илгээж байна» гэсэн утга.
3. **balance\_date** -г үнэн зөв тавь. Тайлагнаж буй өдрөө бич — түүх үүнээс бүрдэнэ.
4. **0 үлдэгдлийг ч илгээ**. Дууссаныг илгээхгүй орхивол систем хуучин тоог үнэн гэж үзсээр байна.
5. **50,000 мөрөөс хэтэрвэл chunk-аар илгээ**, chunk бүрд өөр **idempotency\_key**.
6. Илгээсний дараа **batches/:id** -ээр шалга. **PARTIAL** бол алдаатай мөрөө зас.
7. **HTTPS** заавал. Түлхүүрээ клиент талын код (browser, mobile app)-д битгий байршуул.

## 11. Түлхүүр (API key) авах

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс дараах мэдээллийг ирүүлж авна:

- Байгууллагын нэр, **регистрийн дугаар (7 орон)**
- Байгууллагын төрөл ( **PHARMACY** / **SUPPLIER** / **FACTORY** )
- Холбоо барих хүний нэр, утас, и-мэйл
- Илгээх системийн нэр (вендор)

Түлхүүр нь **нэг байгууллагын** нэр дээр олгогдоно. Нэг вендор олон байгууллагыг төлөөлж илгээх бол тусад нь мэдэгдэнэ (aggregator горим).